

**Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн
хүлээгдлийн мэдээний нэгтгэл**

/2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар/

1. Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэл өмнөх саруудын түвшинд, нийт 29 үйлчлүүлэгч мэргэжлийн эмчид үзүүлэхээр 4-6 хоног хүлээж байна.

Тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэл ихтэй байна. Ор хүлээж байгаа нийт 1172 үйлчлүүлэгч 3-с дээш хоногийн хүлээгдэлтэй байгаа нь өмнөх сараас 50 орчим хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. /Хүснэгт 1/.

**Хүснэгт 1. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж,
үйлчилгээний хүлээгдэл.**

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Нүд судлал	37	63	82	384	566
2	Чих, хамар, хоолой судлал	24	62	120	256	462
3	Урологи	24	32	18	-	74
4	Бүдүүн шулуун гэдэсний мэс засал	7	7	16	-	30
5	Мэс засал судлал	5	7	-	-	12
6	Цусны эмгэг судлал	3	4	1	-	8
7	Зүрх судасны эмгэг судлал	-	3	2	3	8
8	Дотоод шүүрэл судлал	1	5	1	-	7
9	Хоол боловсруулах эрхтэн судлал	3	1	-	-	4
10	Уушигны эмгэг судлал	-	1	-	-	1
	НИЙТ	104	185	240	643	1172

Өмнөх саруудын адилаар Нүд судлал, Чих, хамар, хоолой судлал, Урологийн тасагт хэвтэхээр хамгийн их буюу нийт 1102 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь нийт орны хүлээгдлийн дийлэнх буюу 94%-ийг эзэлж байлаа. Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн 55% нь 1 сараас дээш хугацаагаар ор хүлээж байна.

Лабораторийн болон багажийн шинжилгээний хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.

2. Улсын хоёрдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл өмнөх сараас 37 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Нийт 90 үйлчлүүлэгч амбулаторийн 8 чиглэлийн кабинетийн эмчид үзүүлэхээр 4-с дээш хоног хүлээж байна. Хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж, үйлчилгээнд Хоол боловсруулах эрхтний эмгэг судлал болон эмэгтэйчүүдийн эмчийн үзлэг орж байна./Хүснэгт 2/.

**Хүснэгт 2. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн
тусламж, үйлчилгээний хүлээгдэл**

№	Кабинетын нэр	
---	---------------	--

		Хүлээгдлийн хугацаа		
		4-6 хоног	7-с дээш хоног	Бүгд
1	Мэс засал судлал	2	8	10
2	Хоол боловсруулах эрхтэн судлал	1	32	33
3	Мэдрэл судлал	2	8	10
4	Зүрхний эмгэг судлал	1	-	1
5	Нүд судлал	-	3	3
6	Бөөр судлал	1	13	14
7	Эмэгтэйчүүд судлал	2	15	17
8	Чих хамар хоолойн судлал	-	2	2
	НИЙТ	9	81	90

Амбулаторийн эмчийн үзлэг хийлгэхээр хүлээж байгаа 90 үйлчлүүлэгчийн дийлэнх буюу 90% нь 7-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна.

Тус эмнэлгийн оношилгооны хүлээгдэл өмнөх сартай ижил түвшинд байна. Нийт 42 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байна. Үүнд: хэвлийн эхо-д харуулахаар 17, рентген оношилгоо хийлгэхээр 14, MRI оношилгоо хийлгэхээр 9 үйлчлүүлэгч, холтер хийлгэхээр 2 хүн тус тус хүлээж байна.

Шинжилгээ өгөхөөр нийт 5 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа ба 1 үйлчлүүлэгч биохимийн шинжилгээ, 4 хүн иммунологийн шинжилгээ өгөхөөр тус тус хүлээж байна.

Тус эмнэлэг орны хүлээгдэл өмнөх саруудтай адил их байна. Хэвтэж эмчлүүлэхээр нийт 244 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сараас бага зэрэг буюу 60 үйлчлүүлэгчээр буурчээ. Хоол боловсруулах эрхтэн судлалын тасаг хамгийн их хүлээгдэлтэй, уг тасагт хэвтэн эмчлүүлэхээр 80 үйлчлүүлэгч ор хүлээж байна /Хүснэгт 3/.

Хүснэгт 3. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Хоол боловсруулах эрхтэн судлал	16	64	-	-	80
2	Мэс засал судлал	7	11	-	-	18
3	Чих, хамар, хоолой судлал	-	-	12	13	25
4	Уламжлалт эмчилгээ	10	12	36	-	58
5	Урологи	8	5	-	-	13
6	Эмэгтэйчүүдийн эмгэг судлал	12	24	-	-	36
7	Зүрх судасны эмгэг судлал	3	11	-	-	14
	НИЙТ	56	127	48	13	244

Уламжлалт эмчилгээ хийлгэхээр 58, эмэгтэйчүүдийн тасагт хэвтэж эмчлүүлэхээр 36 үйлчлүүлэгч тус тус 3-с дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тусламжид хамаарч байна.

3. Геронтологийн үндэсний төв

Тус төв нь тусламж үйлчилгээний хүлээгдэлгүй байна.

4. Арьсны өвчин судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулатори болон лабораторийн тусламж, үйлчилгээ нь өмнөх сарын адилаар хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин Арьс харшлын тасагт хэвтэхээр 120 үйлчлүүлэгч 3-6 хоног, 10 үйлчлүүлэгч 7-14 хоног, нийт 130 үйлчлүүлэгч хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа нь өмнөх сараас 3 дахин буурсан үзүүлэлттэй байна.

5. Улсын гуравдугаар төв эмнэлэг, ХСҮТ, ГССҮТ, Амгалан АГТМЭ, Өргөө АГТМЭ, Хүрээ АГТМЭ, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, хүүхэд, нярайн төв-2 болон Нийслэлийн эрүүл мэндийн газар хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.